



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/196

Мандалговь

┌ Арга хэмжээ зохион байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6"л" заалт, Аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/343 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Мандалговь хотод зохион байгуулагдах "Бага олимп-2017" спортын наадмын үеэр аймгийн Засаг даргын 2017 оны 1/972 албан тоотыг хэрэгжүүлж, 10 дугаар сарын 20,21,22-ны өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэхийг хориглосугай.

2.Захирамжийн дагуу тухайн өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэхгүй байхыг ААНэгж, байгууллагын захирлуудад үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Саранзаяа/, хэсгийн төлөөлөгч дэслэгч /Б.Эрдэнэбаатар/, хэсгийн байцаагч ахлах дэслэгч /Д.Цэвэлмаа/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Р-МӨНХТОГТОХ